



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

# БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# #7

2022 он

X сар

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

## “МОНГОЛЫН БОЛОВСРОЛ ӨНӨӨДӨР” үндэсний нэгдсэн судалгааны ажлыг эхлүүлээ

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс санаачлан “МОНГОЛЫН БОЛОВСРОЛ ӨНӨӨДӨР” үндэсний нэгдсэн судалгааны хүрээнд “0-24 насны хүүхэд, залуучуудын боловсролын үйлчилгээнд хамрагдалт-2022” платформд тулгуурлан хийгдэх судалгааны бэлтгэл ажил хийгдлээ.

МОНГОЛЫН БОЛОВСРОЛ  
ӨНӨӨДӨР Үндэсний Нэгдсэн  
Судалгаа

Биднийг Фейсбүүк дээр дагах уу?

Манай Ютүүб сувагт зочилоорой!

Дискорд серверт элсэн платформын хөгжүүлэлтэд оролцох уу?

### Хянах самбар

  
  
[Нүүц үгээ мартсан уу?](#)  
  

Хэрэглэгч болж амжаагүй байна уу? [Бүртгүүлэх](#)

[Click for English](#)

2022 © Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Энэхүү судалгааны платформ нь онлайн болон оффлайн хэлбэрээр компьютер, гар утас, таблет дээр суурилсан байх ба БСҮХ мэргэжлийн багтай хамтарч тус платформыг хөгжүүлж байна.

БСҮХ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас жил бүр гаргадаг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Education at glance” олон улсын судалгааны арга зүйн хүрээнд “Монголын

боловсрол өнөөдөр” үндэсний нэгдсэн судалгаатай байх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд энэ хүрээнд “0-24 насны хүүхэд, залуучуудын боловсролд хамрагдалт-2022” судалгаанд Монгол улсын нийт 920,165 өрх хамрагдах ба өрхийн мэдээлэл цуглуулах нийт 4600 мэдээлэл цуглуулагч ажиллах юм.

ҮНДЭСНИЙ СУРГАГЧ-СУДЛААЧ бэлтгэж, бэлтгэгдсэн сургагч-судлаачаар дамжуулан

орон нутгийн түвшинд ажиллах мэдээлэл цуглуулагч нарыг бэлтгэнэ. Монгол Улсын 0-24 насны хүүхэд, залуучуудын боловсролын үйлчилгээнд хамрагдалт, боловсролын үйлчилгээний гадуур байгаа талаарх мэдээллийн сан үүсч, үндэсний болон орон нутгийн түвшинд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй цаашид хамтран ажиллах хүний нөөц бэлтгэгдэх ажлын суурь болж байна.

**ҮНДЭСНИЙ СУРГАГЧ-СУДЛААЧИД бэлтгэгдлээ**

"0-24 насны хүүхэд, залуучуудын боловсролын үйлчилгээнд хамрагдалт-2022" судалгааны хүрээнд 10 дугаар сарын 13-наас 14-ны өдрүүдэд сургалт зохион байгуулж, 30 сургагч судлаачтай бэлтгэгдлээ.

**СУРГАГЧ-СУДЛААЧ бэлтгэгдлээ**

Мэдээлэл цуглуулагчийг бэлтгэх, чадавхжуулах дүүрэг, орон нутгийн сургагч-судлаачдыг тусгайлан, чадавхжуулах хэрэгцээ үүссэний үндсэн дээр аймаг, дүүргийн сургагчдыг бэлтгэх сургалтыг зохион байгууллаа.

Сургалтад БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд болон аймаг, дүүргийн нийт 87 оролцогч хамрагдаж судалгааны арга зүй болон платформын эхний хувилбар дээр ажиллалаа.



## “МОНГОЛЫН БОЛОВСРОЛ ӨНӨӨДӨР” үндэсний нэгдсэн судалгааны зорилго, ач холбогдол, зохион байгуулалт, цар хүрээ, бэлтгэл ажил, цаашдын хамтын үйл ажиллагааны талаар танилцуулах уулзалт



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн “МОНГОЛЫН БОЛОВСРОЛ ӨНӨӨДӨР” үндэсний нэгдсэн судалгааны талаар

- Ерөнхийлөгч, УИХ-ын харьяа байгууллагууд
- Засгийн газрын яам, агентлаг
- Олон улсын байгууллагууд /НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, ЮНЕСКО
- Үндэсний болон орон нутгийн байгууллагуудын төлөөлөлтэй санал солилцлоо.

“Монголын боловсрол өнөөдөр” үндэсний нэгдсэн судалгааны хамрах хүрээнд Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж эхлээд байна.

### Хүнийг нөөцийг чадавхжуулах сургалт Багахангай дүүрэгт

“Монголын боловсрол өнөөдөр” үндэсний нэгдсэн судалгааны хүрээнд хийх “0-24 насны хүүхэд, залуучуудын боловсролын үйлчилгээнд хамрагд алтын байдал - 2022” судалгааны мэдээлэл цуглуулагчдад зориулсан сургалтыг Нийслэлийн Багахангай дүүрэгт амжилттай зохион байгууллаа.



## Бүх нийтийн МХХТ-ийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулагдав

Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/310 дугаар тушаалаар “Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг БШУЯ, ЦХХХЯ, БСҮХ, БЕГ, БМТТ, И-Монгол академи, МУБИС, МУИС, ШУТИС, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүүхдийн сан, IRIM судалгааны хүрээлэн зэрэг 12 байгууллагын 22 гишүүнтэйгээр байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгийг БСҮХ-гийн захирал М.Итгэл (Ph.D) ахалж байгаа бөгөөд Монгол Улсын бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлж, суурь судалгаа авч, 3 түвшний сургалтын хөтөлбөр боловсруулах юм.

## "ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫН ХЭРЭГЦЭЭ ТОДОРХОЙЛОХ" судалгааны ажлын даалгавар боловсруулагдлаа

Бодлогын баримт бичиг



Тогтвортой хөгжлийн зорилт-2030



“Алсын хараа 2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны баримт бичиг



Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө 2021-2030



Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

- ▶ “Цахим Үндэстэн” баримтлах чиглэл,
- ▶ Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2022-2026

Дээрх бодлогын баримт бичгүүдэд “... бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм эдийн засгийн бүхий л салбарт инновац хийх чадвартай бүтээлч иргэдтэй болно.” гэж заасан байна.

Дэлхий нийтээрээ цахимд шилжиж байгаа өнөө үед компьютер, хөдөлгөөнт төхөөрөмж болон бусад тоног төхөөрөмжтэй харьцах, хэрэгцээт мэдээллийг эрж хайх, контент бүтээдэг хүнийг энгийн чадвартай тооцогдож байна. Монгол улсад 2018 онд иргэдээс авсан Мэдээлэл, харилцаа холбооны

технологи ашиглах чадварыг үнэлэх түүвэр судалгаагаар бүх нийтийн цахим ур чадварын үзүүлэлт 31 хувь гэж тодорхойлогджээ. Харин үндэсний статистикийн хороо, харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран 2021 онд “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо,

технологийн хэрэглээ” түүвэр судалгаа хийгджээ. Нийт судалгаанд оролцогчдын 43.8 хувь нь мэдээллийн ур чадвартай буюу мэдээлэл хайж олох, үйлчилгээний байгууллагуудын веб сайтаас мэдээлэл авах, дижитал орчинд өгөгдөл, мэдээлэл, агуулгыг хуулбарлах, шилжүүлэх, хэрэгсэл ашиглах, файл хадгалах зэрэг чадваруудыг эзэмшсэн байна.

Олон Улсын Цахилгаан Холбооны байгууллага (OECD)-ын зөвлөмжийн дагуу “Өрхийн болон хүн амын МХХТ-ийн хэрэглээ”-ний үзүүлэлтийг тодорхойлж, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтийг бодитой тооцоход Монгол улсын тоо баримтыг тусгах, Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/-ын хэрэгжилт, үр дүнг хэмжих, салбарын бодлогын баримт бичиг боловсруулах, стратегийн ач холбогдол бүхий төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд статистик мэдээ мэдээллээр хангах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Монгол улсын иргэдийн МХХТ-ийн хэрэгцээний өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор хийгдэж буй “Иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ тодорхойлох түүвэр судалгаа”-ны ажлын даалгавар боловсруулагдан гараад байна.

Энэхүү судалгааг баруун, хангайн, төвийн, зүүн бүс тус бүрээс 1 аймгийн төв, 1 сумыг түүврээр, нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийг сонгон тоон болон чанарын судалгааны аргуудыг зохистой хослуулан өгөгдөл цуглуулан статистик аргаар боловсруулалт хийнэ.

Аймгийг сонгохдоо бүс бүрээр санамсаргүй түүврийн аргыг хэрэглэнэ.

Тухайн аймгаас сумыг сонгохдоо аймгийн төвөөс хамгийн их алслагдсан, хүн амын тоо цөөн, МХХТ-ийн дэд бүтэц тааруу зэрэг үзүүлэлтийг харгалзан сонгоно.

Дараах оролцогчдоос түүвэрлэн мэдээлэл цуглуулна. Үүнд:

- Үндэсний статистикийн хорооны насны ангиллын дагуу иргэдийн төлөөллийг хамруулсан байна.
- Зорилтот бүлгийг хамруулсан байна.

Судалгааны хэрэглээ, ач холбогдол:

- Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээний ур чадварыг оновчтой тодорхойлоход суурь мэдээлэл болно;
- Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн ур чадварын ахицыг хэмжих үндэс болно.

## БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд сургалтад хамрагдлаа



1. Боловсролын чиглэлээр судалгааны ажил эрхэлдэг эрдэм шинжилгээний ажилтнуудад судалгааны бүтээлээ олон улсын түвшинд бичих, хэвлүүлэх, байршуулахад нь холбогдох мэдээллээр хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор

Сургалтын ач холбогдол

- Олон улсын судалгааны сэтгүүлийн ангилал, судалгааны цахим сангийн талаарх мэдээлэл;
- Олон улсын судалгааны цахим сангуудад бүртгүүлэх, бүтээлээ байршуулах;
- Судалгааны бүтээл бичих, хэвлүүлэхэд мөрдөх ёс зүй;

БСҮХ-ийн захирал М.Итгэл (Ph.D), секторын эрхлэгч Х.Отгонбаатар (Ph.D) нарын удирдан зохион байгуулсан “Олон улсын түвшинд судалгааны бүтээл бичих, хэвлүүлэхэд анхаарах зарим зүйлс” сэдэвт сургалтад хүрээлэнгийн бүх эрдэм шинжилгээний ажилтнууд хамрагдав.

- Судалгааны ажлын бүтээлийн хулгайг iThenticate программаар шалгах;

“Боловсролын судалгааны сэтгүүл”-ийн цахим систем ба сэтгүүлд өгүүлэл илгээх, хэвлүүлэх; үйл явц зэрэг сэдэв, агуулгын хүрээнд дадлага ажил, хэлэлцүүлэг хэлбэрээр мэдлэг, ойлголт, чадвараа бэхжүүлээ.



2. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Боловсролын үнэлгээний төвөөс мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалт зохион байгуулдаг Кембрижийн үнэлгээний сүлжээ байгууллагатай хамтран 2022 оны 8-р сарын 15-аас 12-р сарын 31-ний хооронд зохион байгуулж буй боловсролын үнэлгээний мэргэжилтнийг чадавхжуулах сургалтад эрдэм шинжилгээний ажилтнууд хамрагдаж байна.

### Монгол хүүхдийн хөгжлийн судалгааны үр дүнг танилцуулах ажил хийгдлээ



БСҮХ-ийн ХХСС-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд 10-р сард **Хэлэлцүүлэг 1:** “Монгол хүүхдийн хөгжлийн суурь судалгааны үр дүнд болон үр дүнд тулгуурласан хөгжлийн шалгуур үзүүлэлт”-ийг Эрдмийн зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлэг явуулсан нь энэ сарын онцлох ажил байлаа.

**Хэлэлцүүлэг 2:** Монголын үндэсний холбооны академиас зохион байгуулсан “Хүүхдийн спорт ба Ирээдүй” сэдэвт олон улсын XII форумд “Өсвөр насны


хүүхдийн бие бялдрын хөгжил”, “Монголын биеийн тамир, спортын шинжлэх ухааны боловсон хүчин бэлтгэж ирсэн түүхийн зарим асуудлууд” сэдвээр 2 илтгэл хэлэлцүүлсэн.

“Монгол хүүхдийн цогц хөгжлийн онцлог” суурь судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан

“3-17 насны хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн шалгуур, үзүүлэлт”-ийг 2022 оны 10-р сарын 21-ний өдрийн Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлууллаа.



## Суралцагчдын цахим сургалтын бэлэн байдлыг тандах судалгаа



Цахим боловсрол, сургалтын тогтолцоо нь мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилан цаг хугацаа, орон зайнаас үл хамаарсан, тэгш, хүртээмжтэй боловсрол олгох, удирдах, сурган хүмүүжүүлэх ажлыг зохион байгуулахад чиглэсэн өргөн хүрээтэй экосистемийн нэг хэсэг юм. Дэвшилтэт технологийг ашиглан боловсрол, сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах нь цахим сургалтын үндсэн үүрэг төдийгүй багш, суралцагчдад суралцахуйн дэмжлэг үзүүлэн, сонголтот хувилбаруудыг санал болгодгоороо илүү ач холбогдолтой.

Суралцагчдын цахим сургалтын бэлэн байдлыг тандах судалгаа нь олон улсын судалгааны асуулгыг ашиглан манай улсын ерөнхий боловсрол (ахлах), мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын цахим сургалтын бэлэн байдлыг техник чадамж, багштайгаа харилцах чадамж, хамт олонтойгоо харилцах чадамж, харилцааны чадамж хоорондын хамаарлыг судлах зорилготой. Судалгаанд нийт 5418 суралцагчид, үүнээс ерөнхий боловсролын 2078, мэргэжлийн боловсролын 1991, дээд боловсролын 1349 суралцагчид хамрагдсан. Мөн ерөнхий боловсролын 412, мэргэжлийн боловсролын 358, дээд боловсролын 332 багш нар оролцсон байна.



Судалгааны дүн: Суралцагчдын цахим сургалтын бэлэн байдалд фактор анализын шинжилгээ SPSS, SPSS-AMOS программуудыг ашиглан хийсэн. Судалгааны үр дүнд тухайн сургуулийн байршил, суралцагчдын нас, хүйс зэрэг нь цахим сургалтын бэлэн байдалд нөлөөлдөггүй. Харин суралцагчдын өөрийн компьютертой, интернэтийн боломж хангалттай байх зэрэг нь цахим сургалтын бэлэн байдалд нөлөөлдөг байна. Хамаарлын шинжилгээгээр техник чадамж, багштайгаа болон хамт олонтойгоо харилцах чадамж, харилцааны чадамжууд нь хоорондоо эерэг хамааралтай байна. Мөн багшаас суралцагчдын цахим бэлэн байдлын судалгааг авсан бөгөөд суралцагчидтай харьцуулсан үр дүнгээс багш суралцагчдын хооронд зөрүүтэй байдал ажиглагдсан.

## Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн судалгаа



Ерөнхий боловсролын хөтөлбөрийн үзэл баримтлалын хүрээнд сурах бичгийн чиг хандлага, асуудал, шийдлийг илэрхийлсэн зураглал гаргаж, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын орчны чиг хандлагын талаар 14 чиглэлийг боловсрууллаа. ЕБС-ийн бага, суурь, бүрэн дунд боловсролын физик, хими, биологи, эрүүл мэнд, монгол хэл, уран зохиол, түүх нийгэм, зураг зүй технологи, англи, орос хэл, биеийн тамир, мэдээллийн технологи, математик (бага боловсрол) хичээлийн бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын жишиг хэрэглэгдэхүүний жагсаалтыг боловсруулж, уншилт хийгдэж байна.

\*Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд “Current Situation and Prospects of Higher Education of Engineering and Technology in Mongolia” нэртэйгээр хэвлүүлэх эрдэм шинжилгээний өгүүллийг хэлэлцүүлээд байна.

\*“Бага боловсролын монгол хэлний унших эхийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд бага боловсролын монгол хэлний хичээлийн “Эхэд тавих шаардлага” -шаардлагад нийцсэн эхийн санг бүрдүүлэх ажлыг хийгдэж эхэлсэн.

**Зөвлөмж**

Казахстаны Багш нарын мэргэжил дээшлүүлэх “Өрлеу” төвөөс 2022 оны 9 сарын 30-нд зохион байгуулж явуулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал “ПОЛИЯЗЫЧИЕ КАК ОДИН ИЗ ПРИОРИТЕТОВ СОВРЕМЕННОГО ОБРАЗОВАНИЯ: СОСТОЯНИЕ И ПЕРСПЕКТИВЫ” (Олон хэлтэй байх нь орчин үеийн боловсролын нэн тэргүүний зорилтуудын нэгэн: өнөөгийн нөхцөл байдал, ирээдүй”) -д хос хэлний АХИС арга зүйгээр туршсан судалгааны үр дүнгийн талаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Түүнчлэн хос хэлний АХИС загварыг таниулах багш нарын гарын авлага болох зөвлөмжийг хэвлэн түгээхэд бэлтгэж байна.

**Сургалтын модуль**

Сургалтын байгууллагад тав, арав дахь жилдээ ажиллаж буй хөгжмийн багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын модуль боловсруулагдлаа. Энэ удаагийн ЕБС-ийн 100 гаруй хөгжмийн багш нарт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, нэгж ээлжит хичээлийн төлөвлөлт боловсруулах, баримт нотолгоонд тулгуурлан төлөвлөлтөө сайжруулах аргачлал зэргээр вебинар сургалтыг зохион байгуулав.

**Сургалт 1. ХГСА (Хичээлээс гадуурхи сургалтын ажил)-ын үлгэрчилсэн хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх сургагч багшийн сургалт зохион байгуулагдлаа**

Сургалтад аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газрын хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудын төлөөлөл бүхий 90 гаруй албан хаагчид хамрагдсан. Боловсрол, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр БСҮХ, БЕГ, сургагч багш нарын багтай хамтран сургалтыг зохион байгуулсан. Сургалт нь “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг таниулах, хэрэгжилтэд арга

зүйн дэмжлэг үзүүлэх, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилготой.

Мөн тэд эцэг эх, асран хамгаалагчийг ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд оролцоход дэмжлэг үзүүлэх, түншлэх, хичээлээс гадуурх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах нэгдсэн ойлголттой болж, хэрэгжүүлэх арга зүйг эзэмшлээ.

**Аймаг, нийслэлийн архивын албан хаагчдад сургалт зохион байгууллаа**

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Гадаад харилцааны яам, Архивын ерөнхий газар, хамтран 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Нийслэлийн нийт архив бичиг хэргийн 1000 гаруй байгууллагын төлөөллийг оролцуулан Монгол бичгийн сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр сургалтыг зохион байгууллаа. Сургалтын зорилго нь Нийслэлийн нийт архив, бичиг хэргийн ажилтнуудад

Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөх, баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага стандартыг танилцуулах, хэрхэн турших, хэвлэх, хэрэглээний фонтыг хэрхэн суулгах, бичих, мөн оролцсон 1000 байгууллагын ажилтнуудын Монгол бичгийн мэдлэгийг шалгах тандалтын сорилыг цахимаар авч, үр дүнг нь өөрсдөд нь мэдээлэх зэрэг ач холбогдолтой боллоо.



Сургалт цахимаар 2022 оны 10 дугаар сарын 26-наас 28-ны өдрүүдэд 21 аймаг, 330 сумын архив, бичиг хэргийн (4700 орчим) ажилчдад бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулав.

**“WELCOME”, “ЗӨВЛӨГЧ СУРАГЧ” хөтөлбөр амжилттай хэрэгжиж эхэллээ.**

“Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу Ахлах ангийн сурагчдад зориулсан англи хэлний нэг жилийн эрчимжүүлсэн “WELCOME”, “ЗӨВЛӨГЧ СУРАГЧ” хөтөлбөрт оролцох сургуулиудын сонгон шалгаруулалт явагдлаа. Тус хөтөлбөрийг нийслэл,

аймаг, сумдын нийт 150 гаруй сургууль БСҮХ-ийн Гадаад хэлний төвд материалаа ирүүлсэн бөгөөд 20 сургууль “WELCOME”, 50 сургууль “Зөвлөгч сурагч” хөтөлбөр хэрэгжүүлэх байгууллагаар тус тус шалгаран үйл ажиллагаагаа эхлээд байна. Тус хөтөлбөр нь 2023 оны 05 сарын 31-нийг дуустал хэрэгжих бөгөөд WELCOME хөтөлбөрт

ахлах ангийн 480 гаруй суралцагч, “Зөвлөгч сурагч” хөтөлбөрт 600 гаруй суралцагч англи хэлний эрчимжүүлсэн сургалтад хамрагдаж байна. Гадаад хэлний төв нь хөтөлбөр хэрэгжүүлж буй сургуулиудын багш нарт цахим уулзалт хийж, хичээл сургалтын үйл ажиллагааны явц болон цаашид хэрэгжүүлэх ажилд удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.